



Ерөнхийлөгч Томас С.Монсон

“Тэр Амилсан!”

Христийн амилалтын баярын анхны өглөө хоосон байсан булц, “Хэрэв хүн үхвэл, тэр амилах уу?” гэсэн Иовын асуултын хариу болсон юм.

Энэ удаагийн хуралдаан үнэхээр гайхамшигтай боллоо. Миний бие Сүмийн Ерөнхийлөгчийн хувиар үг хэлсэн, дуулж хөгжимдсэн нийт оролцогчдын өмнөөс англи хэлний хамгийн чухал гурван үгийг энэ мөчид хэлье гэж бодлоо. Шерил Лант эгч, түүний зөвлөхүүд, найрал дуулаачид, хөгжимчид, үг хэлэгчдэд хандан “Баярлалаа та нартаа” гэж хэлье.

Би олон жилийн тэртээ Английн Лондонд байх үеэрээ алдарт Тейтийн уран зургийн үзэсгэлэнг үзэж билээ. Гейнсбороу, Рембрандт, Констейвл болон нэрд гарсан бусад зураачдын бүтээлүүдийг үзэсгэлэнгийн олон танхимд дэлгэн тавьсан байлаа. Миний бие уран зургийн төгс сайханд сэтгэл татагдан биширч, тийм хосгүй уран бүтээлийг бий болгоход ямар их ур чадвар шаардагддаг бол доо хэмээн бодож билээ. Гэтэл гуравдугаар

давхрын нам гүмхэн буйдхан буланд зөвхөн миний анхаарлыг төдийгүй, зүрх сэтгэлийг минь эзэмдсэн нэг зураг байлаа. Зураач Франк Бреймли далайн салхины өөдөөс харсан даруухан бяцхан байшин зуржээ. Эзгүй байгаа загасчны эхнэр, ээж хоёр түүнийг эргэж ирэхийг шөнөжингөө хүлээжээ. Үүр цайж, загасчин эр далайд живэн, эргэж ирэхгүй болсон нь тодорхой болов. Загасчны залуу эхнэр хадам ээжийнхээ өвөр дээр нь доошоо харан хэвтэж, цөхрөлийн гашуун нулимсаа урсгана. Цонхон дээрх асч дууссан лаа тэд хэчнээн удаан хүлээж, цөхрөнгөө барсныг харуулна.

Залуу эмэгтэйн зүрх шимшрэм үй гашууг би тэр үед мэдэрсэн. Зураач уран бүтээлээрээ дамжуулан гунигт түүхийг мартагдахын аргагүй, амьд юм шиг дүрсэлжээ. Тэр зураг: “*Горьдлого тасарч, үүр гэгээрэв*” гэсэн нэртэй байлаа.

Хөөрхий, тэр залуу эмэгтэй тайтгарлыг хэчнээн их хүсч байсан бол? Бүр Роберт Люиз Стивенсоны “Дуулал” шүлэгт ийн өгүүлдэг:

*Далайчин эр далайгаас гэртээ
эргэн иржээ
Анчин эр уулнаас гэртээ эргэж
ирлээ хэмээх дууллын
үнэнийг тэр чухамхүү
эгээрэн хүсч байсан болов уу.¹*

Мөнх бус амьдралын олон үнэний дотроос, юм бүхэнд төгсгөл ирнэ гэдэг нь хамгийн бодит үнэн билээ. Үхэл хүн бүрд ирнэ. Энэ бол бид “бүгдийн өвлөн авсан шинж чанар. Үхэл хүнийг нялх балчирт нь, бага залууд нь, амьдралын оргил үед нь дайрч болно. Эсвэл үхэл хүнийг цал буурал тэргүүнийх нь үс цас мэт цайхыг хүлээж болно. Осол аваар, өвчин эмгэг, эсвэл зүгээр л байгалийн жамаар хүмүүст үхэл ирж болно. Ямар ч байдлаар байсан, үхэл ирэх нь дамжиггүй.”² Энэ нь дотны хүнээ алдах үй гашуу, нас залуу, цус шингэн хүмүүс мөрөөдөл, хүсэл эрмэлзэл, итгэл найдвар нь биелж амжаагүй байтал цэл залуугаараа хорвоог орхихын харууслыг авчирдаг юм.

Хайртай нэгнээ алдсан эсвэл өөрөө ч бас удалгүй хорвоог орхих нь гарцаагүй гэдгийг ойлгосон мөнх бус хүн бүр, харагддаг зүйлийг харагддаггүй зүйлээс тусгаарладаг хөшигний цаана юу тохиохыг тунгаан боддоггүй гэж үү?

Олон зууны тэртээ өдий төдий эд хөрөнгө, эд баялагаар адислагдсан Иовт, хүний амьдралд тохиолдож болох бүхий л гай зовлонг

биеэрээ туулсан юм. Тэрээр нөхөд-тэйгөө зэрэгцэн сууж, “Хэрэв хүн үхвэл тэр амилах уу?”³ гэсэн цагийн уртад өөрчлөгдөөгүй, мөнхийн асуултыг асуусан юм.

Эрэгтэй, эмэгтэй хүн бүрийн тунгаан боддог зүйлийн тухай Иовийнхүү өгүүлсэн билээ.

Христийн амилалтын энэхүү баярт өглөө би “Хэрэв хүн үхвэл тэр амилах уу?” гэсэн Иовын үгсийг дахин санаж, энэ асуултын хариу нь зөвхөн буурь суурьтай тунгаан бодолт биш, харин Бурханы илчилсэн үгнээс ирдэг гэдгийг хэлэхийг хүсч байна. Хамгийн чухал зүйлээс эхэлье.

Бидний амьдардаг энэ дэлхийд ямар нэг загвар байдаг бол энэхүү Загварыг Зохиогч гэж байх ёстой. Ертөнц дахинд тохиодог олон гайхамшгийг хараад бүх хүн төрөлхөнд зориулсан загвар буюу төлөвлөгөө бий гэдэгт хэн итгэхгүй байх юм бэ? Загвар Зохиогч бий гэдэгт хэн эргэлзэх юм бэ?

Эхлэлийн номноос бид Агуу Бүтээгч тэнгэр, газрыг бүтээснийг мэддэг. “Газар нь ямар ч хэлбэр дүрсгүй, эзгүй хоосон, гүний гадаргуу дээгүүр харанхуй бүрхсэн байлаа.”

“Тэрэл бий болог” гэж Агуу Зохион Бүтээгч хэлэхэд, “гэрэл бий болов.” Тэрээр огторгуйг бүтээж, уснаас хуурай газрыг салгаад, “Газар дэлхий нялх ногоо, . . . үрт жимсний модыг төрөл төрлөөр нь ургуулаг” гэв.

Тэрээр нар, сар хэмээх хоёр гэрлийг бүтээв. Түүний төлөвлөснөөр одод бий болов. Тэрээр усан дахь амьд амьтад, агаарт нисдэг

жигүүртнүүдийг бий болго гэв. Энэ нь ёсоор болов. Тэрээр мал адгуус, мөлхөгчдийг бий болгов. Төлөвлөгөө бараг дуусах дөхөж байлаа.

Хамгийн сүүлд Тэрээр Өөрийнхөө дүр төрхөөр эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээж, бусад амьд бүхнийг тэдэнд захируулсан юм.⁴

Зөвхөн хүн л оюун билэг, тархи, сэтгэн бодох ухаан, сүнс хүлээн авчээ. Оюун билгийн эдгээр шинж чанаруудыг эзэмшсэн хүн л гагцхүү итгэл найдвар, хүсэл эрмэлзлийн болон сүнслэг удирдамж хүлээн авах чадвартай байдаг.

Агуу Зохион Бүтээгчийн шилдэг бүтээл болох, бүх амьд зүйлсийг захирдаг, сэтгэн бодох тархи болон хүсэл зориг, бодол болон бодгалтай, оюун билэг болон бурханлаг шинж чанарыг өвлөсөн хүний сүнс дэлхийн биеийг нь оршиход оршихоо больдог гэж хэн үнэмшилтэйгээр итгүүлж чадах юм бэ?

Бид үхлийн утга учрыг ойлгохын тулд амьдралын зорилгыг ойлгох ёстой юм. Сулавтар итгэлийн оч, илчлэлтээс ирдэг тод гэрлээр өсөн хүчирхждэг. Бид мөнх бус байдалд ирэхээсээ өмнө амьдарч байснаа энэхүү гэрлээр мэддэг билээ. Бид мөнх бус байдлын энэхүү сорилт бэрхшээлтэй атлаа зайлшгүй шаардлагатай оршихууд ирэх боломжтой болсныхоо төлөө баяр хөөр болон уухайлсан Бурханы хөвгүүд, охидын дунд мөнх бус байдлын өмнөх оршихууд байхдаа уг гэрэлд огтхон ч эргэлзэхгүй байсан юм.⁵ Бидний зорилго бол бие-тэй болж, сорилт бэрхшээлийг даван туулж, Бурханы зарлигуудыг

сахихаа нотлон харуулах явдал гэдгийг бид мэдэж байсан юм. Бид мөнх бус байдлынхаа улмаас уруу татагдаж, нүгэл үйлдэн, зорилгодоо хүрж чадахгүйг Эцэг маань мэдэж байлаа. Амжилтад хүрэх бүх боломж бидэнд байхын тулд Тэрээр бидэнд бидний төлөө зовон шаналж, амь насаа өргөх ёстой Аврагчийг өгсөн билээ. Тэрээр зөвхөн бидний нүглийг цагаатгасан төдийгүй, бас тэрхүү Цагаатгалын хэсэг болгон, Адамын Уналтын улмаас бид эрхшээлд нь орсон биеийн үхлийг ялсан юм.

Тийнхүү бидний Аврагч Христ 2000 гаруй жилийн тэртээ Бетлехемд малын хашаанд мөнх бус амьдралд мөндөлж, эрт дээр үеэс угтан хэлж байсан Мессиа ирсэн билээ.

Есүсийн хүүхэд ахуйн тухай өгүүлсэн зүйл маш бага байдаг. “Есүсийн бие болон мэргэн ухаан нь өссөөр байсан бөгөөд Бурханы болон олон түмний тааллыг олжээ”⁶ гэсэн Лукийн судрын хэсэгт би дуртай. Үйлсийн номонд Аврагчийн талаар: “[Тэрээр] сайныг үйлдэж явсан тухай”⁷ өгүүлсэн утга төгөлдөр, богинохон өгүүлбэр байдаг.

Тэрээр Иордан голд Иоханаар баптисм хүртсэн юм. Арванхоёр Төлөөлөгчийг дуудав. Өвчтэй хүмүүсийг адислан, хазгаруудыг явдаг, хараагүйг хардаг, дүлийг сонсдог болгож явлаа. Тэр ч байтугай Тэр үхсэнийг амьдруулан босгож явлаа. Тэрээр зааж, гэрчилж, мөн бидний дагах ёстой төгс үлгэр жишээг биеэр үзүүлж байлаа.

Дэлхийн Аврагчийн мөнх бус амьдралд гүйцэтгэх үүрэг зорилго

дуусах тийшээ хандаж байв. Тэрээр дээд өрөөнд Төлөөлөгчидтэйгөө хамт сүүлчийн зоог барив. Гетсемани болон Калварын загалмай түүнийг хүлээж байлаа.

Христ Гетсеманид бидний төлөө ямар чухал зүйл хийснийг мөнх бус хүн бүрэн ойлгож чадахгүй юм. Тэрээр Өөрөө хожим нь уг үйл явдлыг: “Бүр бүхнээс хамгийн агуу Бурхан намайг өвдөхийн улмаас дагжин чичрэх мөн сүв бүрээс цус шүүрэх мөн бие хийгээд сүнс аль алиныг нь зовооход хүргэсэн юм”⁸ гэж дүрсэлжээ.

Ийнхүү хүч чадал нь шавхагдаж Гетсеманид зовон шаналсны дараа Түүнийг харгис, бүдүүлгээр баривчилж, Аннас, Каиф, Пилат, Херод нар уруу аваачсан билээ. Түүнд ял тулгаж, хараан зүхэж байв. Харгис балмад үйлдлүүд өвдөлтөөр сүлдсэн биеийг нь улам доройтуулав. Хурц өргөст үүргэнэн титэм толгойд нь хүчээр өмсгөж, толгойноос нь гарсан цус хацрыг нь даган урсаж байлаа. Дараа нь Түүнийг Пилат уруу дахин авчрахад, тэрээр “Түүнийг цовдол, цовдол”⁹ гэж ууртайгаар хашгиралдсан цугларгасдын үгийг дагасан юм.

Хурц үзүүртэй төмөр, яс үзүүрт нь бэхэлсэн гөрмөл суран ташуураар Түүнийг ташуурдаж байлаа. Тийнхүү харгис хэрцгийгээр ташуурдуулсны дараа Тэр загалмайгаа үүрэн арай ядан хөлөө зөөж гэлдэрсээр цааш явж чадахгүй болоход өөр хүн загалмайг нь үүрсэн юм.

Эцэст нь Калварын толгой дээр өмнөөс нь юу ч хийж чадахгүй болсон дагалдагчдынх нь нүдэн дээр, нэл шарх болсон Түүнийг

загалмайд хадав. Түүнийг бүдүүлэг хэрцгийгээр дооглон тохуурхаж, хараан зүхэж байлаа. Гэсэн ч Тэр, “Аав аа, тэднийг уучлаач. Учир нь тэд юу хийж байгаагаа мэдэхгүй байна”¹⁰ гэв.

Тэр амьсгал хураах хүртлээ олон цаг зовсон юм. Омголтсон уруулаас нь, “Аав аа Таны гарт би сүнсээ даатгая” гэсэн үгс гараад тэр амьсгалаа хураасан юм.”¹¹

Үхэл Түүнийг мөнх бус махбодын өвдөлт шаналлаас чөлөөлөхөд амар амгаланг олж Эцэгийнхээ оршихуйд эргэж очуулсан билээ.

Сүүлчийн агшинд Эзэн эргэн буцаж болох байв. Гэвч Тэр тэгээгүй юм. Тэрээр бүх зүйлийг аврахын тулд бүх зүйлээс доогуур орсон юм. Амьгүй болсон цогцсыг нь хүнээс гуйж авсан булшинд яаруу боловч эвтэйхэн аваачиж тавьжээ.

Долоо хоногийн эхний өдөр Эзэнийхээ цогцсыг ариулахаар булшин дээр хүрч ирэн, уйлж унжсан Магдалын Мариа болон нөгөө Мариад хоёр тэнгэр элчийн хэлсэн үгсээс илүү чухал үг Христэд итгэгчдийн ертөнцөд үгүй байхаа.

“Та нар юунд үхэгсдийн дунд амьд Нэгэнийг хайна вэ?

“Тэр энд байхгүй, харин Тэр амилсан”¹² гэж тэнгэр элч хэлжээ.

Бидний Аврагч амилсан. Үхлийг ялсан нь хүн төрөлхтний түүхийн хамгийн яруу алдарт, тайтгаруулах, итгэл найдвар төрүүлсэн үйл явдал болсон юм. Гетсемани, Калвар хоёр дээр болсон өгүүлшгүй бэрх өвдөлт, зовлон шаналал ард үлдэж, хүн төрөлхтний аврал баттай болж, Адамын Уналтыг даван туулсан юм.

Христийн амилалтын баярын

анхны өглөө хоосон байсан булц, “Хэрэв хүн үхвэл, тэр амилах уу?” гэсэн Иовын асуултын хариу болсон билээ. Миний дуу хоолойг сонсох бүх хүмүүст хандан, хэрэв хүн үхвэл тэр амилах болно гэдгийг би тунхаглаж байна. Илчлэгдсэн үнэний гэрэл бидэнд байдаг учраас бид үүнийг мэддэг.

“Учир нь үхэл нь нэг хүнээр ирсэн тул үхэгсдийн амилалт нь мөн нэг хүнээр иржээ.

“Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьдруулагдах болно.”¹³

Христийн Цовдлолтын уй гашууг болон Түүний Амилалтын баяр баяслыг биеэр үзсэн хүмүүсийн гэрчлэлийг би уншсан, үүнд итгэдэг. Амилсан Их Эзэн тэдэн дээр айлчлан ирсэн Шинэ Дэлхийд аж төрж байсан хүмүүсийн гэрчлэлийг би уншсан, үүнд итгэдэг.

Энэ эрин үед, эдүгээ ариун хэмээн нэрлэгддэг болсон ариун ойн цоорхойд Эцэг, Хүү хоёртой ярилцаж, өөрийн гэрчлэлийг цусаараа лацадсан тэр хүний гэрчлэлд би итгэдэг. Тэрээр ийн тунхагласан юм:

“Мөн эдүгээ түүний талаар өгөгдсөн олон гэрчлэлийн дараа, энэ бол түүний талаар өгөх бидний өгөх, хамгийн сүүлчийн гэрчлэл юм: Тэр амьд бөлгөө!

“Учир нь бид түүнийг бүр Бурханы баруун гар талд харсан билээ түүнчлэн тэрээр Эцэгийн Төрсөн Ганц болой хэмээн гэрчлэх дуу хоолойг бид сонссон билээ.”¹⁴

Үхлийн харанхуйг илчлэгдсэн үнэний гэрлээр ямагт сарниулж болно. “Би бол амилалт ба амь мөн.”¹⁵ “Амар амгаланг би та нарт

үлдээнэ. Би Өөрийн амар амгаланг та нарт өгнө”¹⁶ гэж Эзэн хэлсэн юм.

Өнгөрсөн олон жил би Амилалтын үнэн бодит байдлын тухай гэрчлэлээ надтай хуваалцсан хүмүүсийн тоо томшгүй олон гэрчлэлийг сонсож, уншсан. Эдгээр хүмүүс Аврагчийн амласан амар амгалан, тайтгарлыг хамгийн хэрэгтэй үедээ хүлээн авсан байлаа.

Ийм нэгэн түүхийн хэсгээс өгүүлье. Гэр бүлийнхээ тухай, ялангуяа 11 настайдаа өвчтэй болсон хүү Жейсоныхоо тухай бичсэн сэтгэл хөдлөм захидлыг би долоон хүүхдийн эцэг нэг ааваас хоёр долоо хоногийн өмнө авлаа. Сүүлийн таван жилд Жейсоны өвчин хэд дахин хөдөлсөн гэнэ. Жейсон өвчнөө эс хайхран, ааш зан сайтай, баяр баясгалантай байдаг тухай энэ аав бичжээ. Жейсон 12-тойдоо Аароны санваар авч бие нь сайн, муу ямар ч байсан, “үүрэгт ажилдаа үргэлж онцгой хүч чармайлт гаргадаг байжээ.” Тэр 14-тэйдөө Скаутын Бүргэд шагнал авсан гэнэ.

Өнгөрсөн зун Жейсон 15 нас хүрээд удалгүй дахин эмнэлэгт хэвтжээ. Аав нь нэг удаа Жейсоныг эргэж очтол хүүгийн нүд нь аниастай байж гэнэ. Түүнийг унтаж байгаа эсэхийг нь аав нь мэдэлгүйгээр, “Жейсон” гэж аяархан дуугарч, “Миний хүү богинохон амьдралдаа мөн ч ихийг үзлээ. Байдал чинь хэцүүхэн л байна. Агуу тэмцэл чамайг хүлээж байгаа ч гэсэн, Есүс Христэд итгэх итгэлээ хэзээ ч бүү орхиорой” гэжээ. Жейсон гэнэт нүдээ нээж, “Хэзээ ч үгүй!” гэж шийдэмгий дуугаар тодхон хэлэхэд

аав нь цочсон гэнэ. Тэгээд Жейсон нүдээ аньж, дахиад юу ч хэлсэнгүй.

“Жейсон энэхүү энгийн үгээр Есүс Христийн тухай өмнө нь миний хэзээ ч сонсож байгаагүй хамгийн хүчирхэг, ариун гэрчлэлийг илэрхийлсэн юм” гэж аав нь бичжээ. . . . Хэзээ ч үгүй! гэсэн түүний үг тэр өдөр бодгалд минь гүнзгий ул мөрөө үлдээж, ийм сайхан сэтгэлт, агуу хүүгийн эцэг байхаар намайг адисалсан Тэнгэрлэг Эцэгтээ баярлан талархах сэтгэлээр зүрх сэтгэл минь дүүрч билээ. . . . Хайрт хүү минь Христийн тухай гэрчлэлээ сүүлчийн удаа хэлсэн нь энэ байлаа.”

Энэ удаа эмнэлэгт хэвтсэн нь ердөө л ээлжит эмчилгээ нь юм гэж гэрийнхэн нь бодсон ч, Жейсон хоёр долоо ч хонолгүй хорвоог орхисон ажээ. Тэр үед ах, эгч хоёр нь номлолд үйлчилж байсан гэнэ. Өөр нэг ах Кайл нь номлолын дуудлагаа дөнгөж хүлээж аваад байж. Түүний дуудлага цагаасаа нэлээд эрт ирсэн болохоор Жейсонг өөд болохоос яг долоо хоногийн өмнө 8-р сарын 5-нд тэднийхэн гэр бүлээрээ эмнэлгийн өрөөнд хамт очиж, Кайлын номлолын дуудлагыг задлахад, бүгдээрээ байжээ.

Энэ аав надад ирүүлсэн захидалдаа эмнэлгийн орон дээр байгаа Жейсон, орных нь дэргэд номлолын дуудлагаа барин зогсож байгаа ах Кайлынх нь зургийг дотор нь хийсэн байв. Гэрэл зургийн доор: “Хөшигний хоёр талд номлолдоо хамт үйлчлэхээр дуудагдлаа” гэсэн үгс бичсэн байв.

Номлолдоо үйлчилж байгаа Жейсоны ах, эгч хоёр дүүгийнхээ

оршуулга дээр хуваалцах тайтгаруулах сайхан үгстэй захидлыг гэртээ ирүүлсэн гэнэ. Аргентины Буэнос Айресын Баруун номлолд үйлчилж байгаа эгч нь захидлынхаа нэг хэсэгт: “Есүс Христ амьд гэдгийг би мэднэ. Тэр амьд учраас бид бүгд, түүний дотор миний хайрт дүү Жейсон дахин амьдрах болно. . . . Бид мөнхийн гэр бүл болж хамтдаа лацдан холбуулснаа мэддэг учраас тайван байж болно. . . . Хэрэв бид энэ амьдралд дуулгавартай байхын тулд чадах бүхнээ хийвэл, түүнтэй дахин уулзах болно.” Тэрээр цааш өгүүлсэн нь, “Аль эртнээс миний дуртай нэг судар эдүгээ шинэ утга учир, ач холбогдолтой болж байна. . . . Энэ бол Илчлэлтийн бүлэг 21 шүлэг 4 юм: Бурхан тэдний нүднээс нулимс бүрийг нь арчина. Тэнд цаашид үхэл байхгүй болно. Тэнд цаашид гашуудах, уйлах, өвдөх гэж үгүй болно. Анхны юмс өнгөрөн одлоо.”

Хайрт ах, эгч нар минь, сэтгэл эмзэглүүлэм гүнзгий уй гашуу тохиолдсон үед Христийн амилалтын баярын тэрхүү анхны өглөө “Тэр энд байхгүй. Тэр амилсан”¹⁷ гэж хэлсэн тэнгэр элчийн үгсээс бид агуу амар амгаланг олдог билээ.

*Тэр амилсан! Тэр амилсан!
Түмэнд үүнийг баяртай мэдэгд.
Өөрөө тэр гурван өдрийн
шоронгоос босч ирлээ;
Өвч дэлхий даяар баярлаг,
баярлаг.
Үхлийг ялж хүн чөлөөлөгдлөө.
Үнэхээр Христ ялалтыг
авчирлаа!*¹⁸

Бидний үед зориулсан сургаалууд

Өнөөдөр дэлхий дэх Түүний тусгай гэрчүүдийн нэг би Христийн амилалтын энэхүү баярт өглөө энэ бүхэн үнэн гэдгийг Түүний ариун нэрээр, бүр бидний Аврагч, Есүс Христийн нэрээр тунхаглаж байна—амен.

ЭШЛЭЛ

1. Роберт Люиз Стивенсон, "Requiem," *An Anthology of Modern Verse*, Ed. A. Methuen; (1921), 208.
2. James E. Talmage, *Jesus the Christ*, 3 дахь хэвлэл, (1916), 20.
3. Иов 14:14.
4. Эхлэл 1:1–27-г үз.
5. Иов 38:7-г үз.
6. Лук 2:52.
7. Үйлс 10:38.
8. С ба Г 19:18.
9. Лук 23:21.
10. Лук 23:34.
11. Лук 23:46.
12. Лук 24:5-6.
13. 1 Коринт 15:21-22.
14. С ба Г 76:22-23.
15. Иохан 11:25.
16. Иохан 14:27.
17. Матай 28:6.
18. "He Is Risen!" *Hymns*, no. 199.

Дөрөв дэх ням гарагийн мелкизедек санваартнууд болон Нийгмийн Халамжийн бүлгийн хичээлүүд "Бидний үед зориулсан сургаалууд" гэсэн сэдэвт зориулагдах болно. Хичээл бүр дээр хамгийн сүүлийн ерөнхий чуулган дээр хэлсэн нэг юм уу хэд хэдэн үгнээс авч, бэлтгэж болно. Гадас болон дүүргийн ерөнхийлөгчид аль хэлсэн үгнээс ашиглах ёстойг сонгох эсвэл тэд бишоп ба салбарын ерөнхийлөгч нарт энэ үүргийг өгнө. Удирдагчид Мелкизедек санваартай ах нар болон Нийгмийн Халамжийн бүлгийн эгч нар ням гарагт ижил хэлсэн үгнээс суралцаж байгаад гол анхаарлаа хандуулах ёстой. Дөрөв дэх ням гарагийн хичээлд оролцогчдыг хамгийн сүүлийн ерөнхий чуулганы хэлсэн үгнээс судалж, ангид ерөнхий чуулганы хэлсэн үгтэй сэтгүүлийг авчрахыг уриалан дэмжинэ.

Хэлсэн үгнээс хичээлд бэлтгэхэд туслах санаанууд

Хэлсэн үгнээс судлан, заах үед Ариун Сүнс хамт байхыг гуйн зал-

бир. Та хичээл заахад бэлтгэхдээ бусад материалаас ашиглахаар өдөөгдсөн байж болно. Гэвч ерөнхий чуулган дээр хэлсэн үгс нь батлагдсан хичээлийн хуваарь юм. Таны даалгавар бол бусад Сүмийн хамгийн сүүлийн ерөнхий чуулган дээр заасан сайн мэдээнээс суралцаж, түүгээр амьдрахад нь туслах явдал мөн. Хэлсэн үгсийг эргэн сайн судалж, ангийн гишүүдийн хэрэгцээг хангах зарчим болон сургаалуудыг эрж ол. Мөн эдгээр үнэнийг заахад тань туслах хэлсэн үгсэд байгаа түүх, судрын эшлэл, тунхаглуудыг хайн ол. Зарчим болон сургаалуудыг хэрхэн заахыг тоймлон, ноорог хий. Таны ноорог ангийн гишүүдэд:

- Хэлсэн үгэн дэх зарчим ба сургаалуудыг олох
- Тэдний утга санааны талаар бодох
- Ойлголт, санаа, туршлага болон гэрчлэлээ хуваалцах
- Эдгээр зарчим ба сургаалуудыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах асуултуудыг багтаасан байх ёстой.



Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх
Ерөнхийлөгч Хенри Б.Айринг

Гэртээ харихад нь тэдэнд тусал

Бид Бурханы хүүхдүүдийг бага байхад нь Есүс Христ болон Түүний сэргээгдсэн сайн мэдээнд итгэх итгэлийг төлөвшүүлэх арга замуудыг хангаж өгснөөр тэдэнд хамгийн сайнаар тусалж чадна.

А х эгч нар аа, Тэнгэрлэг Эцэг маань сүнсэн хүүхдүүдээ гэртээ Өөр дээрээ ирүүлэхэд бидний тусламжийг хүсдэг бас энэ тусламж Түүнд хэрэгтэй байдаг юм. Би өнөөдөр аль хэзээний Түүний үнэн Сүмд байгаа, тиймээс Тэнгэрлэг гэртээ буцаж очих нарийн бөгөөд шулуун зам дээр гарчихаад байгаа залуу хүмүүсийн талаар ярьж байна. Тэнгэрлэг Эцэг тэднийг зам дээр үлдэх сүнслэг байдлын хүч чадлыг бага байхаасаа олж аваасай гэж хүсдэг. Мөн хэрвээ тэд төөрч эхлэх юм бол тэднийг зам дээр нь даруйхан буцааж гаргахад бидний тусламж Түүнд хэрэгтэй байдаг.

Би залуухан бишоп байхаасаа л хүүхдүүдийг бага байхад нь

төлөвшүүлж, даруйхан аврахыг биднээс Их Эзэн яагаад хүсдэгийг тодорхой харж эхэлсэн билээ. Өнгөрсөн жилүүдэд миний туслахыг хичээсэн олон залуусыг төлөөлөх нэг хүний түүхийг би та нарт ярья.

Тэр эмэгтэй, бишопын ширээний нөгөө талд сууж байлаа. Тэр амьдралынхаа талаар надад ярьж байлаа. Найман настай байхдаа Сүмд багтисм хийлгэн, гишүүнээр батлагдсан байлаа. Тэр явдлаас хойших 20 гаруй жилийн талаар ярихдаа тэрээр нүдэндээ нулимстай байгаагүй ч, дуу хоолой нь гунигаар дүүрэн байлаа. Тэрээр хөгжилтэй хүмүүс гэж өөрийнхөө бодсон хүмүүстэй нөхөрлөх сонголтыг хийснээс нүгэл үйлдэх уруудалтын зам

нь эхэлсэн аж. Тэрээр эхэндээ тийм ч чухал биш санагдсан зарлигуудыг зөрчиж эхэлсэн гэнэ.

Эхлээд тэрээр бага зэрэг гуниг, өчүүхэн төдий гэмшлийг мэдэрсэн аж. Гэхдээ найз нартайгаа нөхөрлөснөөр тэд өөрт нь таалагддаг мэт санагдаж, улмаар наманчлах нь тийм ч чухал биш юм шиг санагдах болсон гэнэ. Зарлигуудыг зөрчих нь илүү ноцтой болох тусам, аз жаргалтай мөнхийн гэр орны мөрөөдөл нь холдон бүдгэрч байлаа.

Тэрээр ширээний нөгөө талд зовлонг байдал гэж өөрийн нэрлэсэн тэр байдалдаа сууж байв. Тэрээр нүглийн хүлээснээс аврахыг надаас хүссэн юм. Гэвч энэхүү нүглийн хүлээснээс мултарч чадах цорын ганц арга зам нь, Есүс Христэд итгэх итгэлээ бодитой болгон, харууссан зүрхтэй байж, наманчлан, тэгснээр ариусгагдан, өөрчлөгдөж, Их Эзэний Цагаатгалаар дамжуулан бат бөх итгэлтэй болох явдал байлаа. Энэ нь боломжтой зүйл учраас би түүнтэй гэрчлэлээ хуваалцсан юм. Мөн энэ нь үнэхээр боломжтой байсан, гэвч энэ нь, Бурхан уруу гэртээ буцаж очих амьдралын аяндаа эртнээс, ялангуяа төөрч эхлэхдээ л итгэлийг бодитой болгож эхэлсэн бол ямар байх байснаас нилээд хэцүү байлаа.

Тиймээс, хүүхдүүдийг бага байхад нь Есүс Христ болон Түүний сэргээгдсэн сайн мэдээнд итгэх итгэлийг нь бататган төлөвшүүлэх арга замыг бэлтгэснээр бид Бурханы хүүхдүүдэд хамгийн сайнаар тусалж чадна. Хэрэв тэд замаас гажиж эхлэх юм бол тэр даруйд итгэл нь мөхөхөөс өмнө итгэлийг нь сэргээж

бат бөх болгоход туслах хэрэгтэй.

Тиймээс, Бурханы хүүхдүүд дундах аялагчдад туслах бараг л байнгын боломж та бидэнд олддоно. Сатан болон гэм нүглийн бий болгодог манан дунд Бурханы сүнсэн хүүхдүүдийн гэртээ буцаж очих аюул осол ихтэй аяллыг Аврагч тайлбарлахдаа яагаад түүнд туслах хэрэгтэйг бидэнд хэлж өгсөн юм:

“Та нар давчуу хаалгаар орогтун; учир нь устгалд хөтлөх тэр зам уужим, мөн хаалга нь өргөн, мөн түүгээр ордог нь олон байдаг.

“Учир юун гэвэл амьдралд удирдах тэр хаалга давчуу, мөн зам нь нарийн, мөн үүнийг олдог нь цөөхөн байдаг.”¹

Тэнгэрлэг Эцэг хүүхдүүдийнхээ хэрэгцээг урьдчилан хараад, туслагчдыг болон удирдамжуудыг зам дээр нь нигүүлсэнгүйгээр байрлуулсан билээ. Тэрээр аюулгүй аян замыг бий болгохын тулд, харах мэлмийтэй байлгахын тулд Өөрийн Хүү Есүс Христийг илгээсэн юм. Тэрээр өнөө үед Ерөнхийлөгч Томас С. Монсонг бошиглогчоороо дуудсан билээ. Залуу байхаасаа л, Ерөнхийлөгч Монсон зам дээр хэрхэн үлдэхийг төдийгүй гай зовлон уруу хөтлөгдсөн хүмүүсийг хэрхэн аврахыг заадаг байлаа.

Тэнгэрлэг Эцэг бусдыг бэхжүүлж, хэрэгтэй үед аялагчдыг аюулгүйгээр удирдах олон янзын ажил үүргийг бидэнд даалгадаг юм. Бидний хүлээн авдаг хамгийн чухал, хариуцлагатай үүрэг гэр бүлд байдаг. Хүүхдийн амьдрал эхлэхэд хөлийг нь тэнгэрлэг гэртээ эргэж очих зам дээр баттай тавих

боломж гэр бүлд байдаг учраас энэ нь маш чухал юм. Эцэг эх, ах эгч нар, өвөө эмээ нар, авга, нагац, үеэлүүд нь, гэр бүлийн хэлхээ холбоо болох хайраар хүрээлэгдсэн байдаг учраас илүү хүч нөлөөтэй удирдагч, хөтөч нь байж чаддаг.

Хүүхдийн амьдралын эхний найман жилд гэр бүл нь нэгэн чухал давуу талтай байдаг. Анхаарал халамжаар дүүрэн байдаг тэдгээр жилүүдэд, Есүс Христийн Цагаатгалын улмаас, гэртээ харих замыг нь нуух харанхуй мананг Сатан хэрэглэх хүчгүй байдаг. Тэдгээр үнэт жилүүдэд, хүүхдүүдийг сүнслэг байдлын хувьд бэхжүүлэхийн тулд Хүүхдийн Хэсгийн ажилтнуудыг дуудсанаар Их Эзэн гэр бүлүүдэд тусалдаг. Түүнчлэн Тэрээр ариун ёслолыг гүйцэтгүүлэхээр Аароны санваартнуудаар хангаж өгдөг. Ариун ёслолын залбиралд, хэрвээ тэд Бурханы зарлигуудыг дуулгавартай дагавал Ариун Сүнснийг хөтчөө болгож чадна гэдэг амлалтыг хүүхдүүд сонсдог. Үүний үр дүнд, тэд уруу таталтыг сөрөн зогсохоор бат бөх болдог бөгөөд хожим нь, ирээдүйн нэгэн цагт, бусдыг аврахаар явах болно.

Сүмийн олон бишоп тойргийн хамгийн бат бөх итгэлтэй хүмүүсийг Хүүхдийн Хэсгийн хүүхдүүдтэй ганцаарчлан ажиллаж, тэдэнд үйлчлүүлэхээр дууддаг. Хэрвээ хүүхдүүд бат бөх итгэл, гэрчлэлтэй болвол өсвөр насанд нь тэднийг аврах хэрэгцээ бага байх болно гэдгийг бишопууд мэддэг. Бат бөх сүнслэг байдлын үндэс суурь нь амьдралд

өөрчлөлт гаргаж болохыг тэд мэддэг.

Бид бүгдээрээ тусалж чадна. Өвөө, эмээ нар, хэн нэгэн хүүхдийг таньдаг гишүүн болгон тусалж чадна. Туслахын тулд Хүүхдийн Хэсэгт албан ёсоор дуудагдсан байх албатай бус юм. Мөн энэ нь хэдэн настайгаас чинь хамаарахгүй. Нэг тийм эмэгтэй, арай залуу байхдаа Хүүхдийн Хэсгийн ерөнхий удирдлагын зөвлөлд байсан бөгөөд “Зөвийг Сонго” гэсэн уриаг бий болгоход тусалсан юм.

Тэрээр хүүхдүүдэд үйлчлэхээсээ хэзээ ч залхаагүй юм. Тэрээр тойргийнхоо Хүүхдийн Хэсэгт, хүсэлтээрээ бараг 90 нас хүртлээ үйлчилсэн юм. Бяцхан хүүхдүүд өөрсдийг нь хайрладаг түүний хайрыг мэдэрдэг байлаа. Хүүхдүүд түүний үлгэр жишээг харж, дагадаг байлаа. Тэд түүнээс Есүс Христийн сайн мэдээний энгийн зарчмуудыг мэдэж авдаг байсан. Хамгийн чухал нь, түүний үлгэр жишээнээс, тэд Ариун Сүнснийг таньж, мэдэрч сурсан байлаа. Тэд тийнхүү сурснаар уруу таталтыг сөрөн зогсох итгэлийн зам дээр баттай гарсан юм. Тэднийг хожим нь аврах шалтгаан бага гарсан ажээ. Мөн тэд бусдыг аврахаар явахад бэлтгэгдсэн байв.

Хүүхдүүд маань жаахан байхад би залбирал болон Ариун Сүнсэнд итгэх энгийн итгэлийн хүч чадлыг сурч авсан билээ. Манай том хүү баптисм арай хийлгээгүй байлаа. Аав ээж хоёр нь, Хүүхдийн хэсгийн багш нар болон санваартан үйлчлэгчид, Сүнснийг мэдэрч, таньдаг болоход нь мөн хэрхэн Түүний тус-

ламжийг авахыг түүнд зааж өгөхийг хичээж байлаа.

Нэг өдөр, эхнэр маань хүүдээ уншихыг заадаг байсан нэг эмэгтэйн гэрт хүргэж өгөв. Би ажлаасаа гэртээ харих замдаа хүүгээ очиж авна гэж бодож байлаа.

Хичээл нь бидний бодож байснаас арай эрт тарсан байлаа. Тэр гэртээ харих замаа мэднэ гэж бодож. Тэгээд, гэр өөдөө алхжээ. Тэр дараа нь, өөртөө их итгэлтэй байснаа, бас, гэртээ харих гээд ганцаараа явж байгаа нь сайхан санагдсан гэж билээ. Хүү маань 0.8 километр газар явчихаад байхад харанхуй болж эхэлсэн бөгөөд тэрээр гэрээсээ нэлээд хол байгаага мэджээ.

Хажуугаар нь өнгөрөх машинуудын гэрэл нулимс цийлэгнэх нүдэнд нь бүдэгхэн харагдаж байсныг нь тэр одоо ч санадаг. Тэр ганцаараа гэр өөдөө алхаж эхэлсэн нөгөөх өөртөө итгэлтэй хөвгүүн биш, харин бяцхан хүүхэд шиг санагджээ. Тэр өөрт нь тусалцаа хэрэгтэйг сая ойлгож гэнэ. Санаанд нь нэг зүйл орж ирэв. Залбирах хэрэгтэйгээ мэдлээ. Тэгээд хүү минь замаас гараад, харанхуйд арай л гэж харагдах хэдэн модны зүг алхжээ. Өвдөг сөхрөн суух нэг газрыг олсон гэнэ.

Бутны цаанаас, хүний дуу гарч, түүнийг чиглэн ирж явааг сонсчээ. Хоёр залуу хүн түүний уйлахыг сонсжээ. Тэд ойртож ирэх зуураа, “Бид чамд туслах уу?” гэж асууж. Хүү минь нулимс асгаруулан төөрснөө болон гэртээ харимаар байгаага хэлсэн гэнэ. Гэрийнхээ утасны дугаар, хаягийг мэдэх үү гэж тэд асууж. Тэр үгүй гэвэл, нэр чинь

хэн бэ гэж тэд асуухад, харин нэрээ л мэдэж байсан гэдэг. Тэгээд тэд хүүг ойролцоох гэртээ дагуулан очжээ. Тэд утасны лавлахаас манайхыг олсон аж.

Хүн утасдахаар би хүүгээ авахаар яаран очлоо. Гэртээ харих гэж төөрсөн үед замд тааралдсан найрсаг хүмүүст би талархал илэрхийллээ. Хүү минь төөрсөн ч туслах хэн нэгэн ирнэ гэсэн итгэлтэйгээр залбирахыг түүнд зааж байсанд би байнга талархалтай байдаг. Тэр цагаас хойш итгэл нь түүний тоолж чадахаас илүү олон удаа түүнийг аюулгүй замаар хөтөлж, туслагчдыг ирүүлж байлаа.

Их Эзэн Өөрийн хаант улсад аврах загвар болон туслагчдыг байрлуулсан юм. Их Эзэн Өөрийн мэргэн ухаанаар, бид өсвөр насыг туулах үед зам дээр нь хамгийн сайн туслагчдыг байрлуулахад, биднийг бэхжүүлэх хамгийн үр нөлөөтэй арга замуудыг бий болгоход үйлчлэгчдээ удирдан чиглүүлдэг.

Их Эзэний бэлтгэж өгсөн үр нөлөөтэй хөтөлбөрийн хоёрыг та нар мэднэ. Нэгдүгээрт, залуу эмэгтэйчүүдэд энэ нь “Хувийн Хөгжил Дэвшил” гэж нэрлэгддэг. Нөгөө нь, Аароны санваартнуудад зориулагдсан бөгөөд “Бурханы өмнө хүлээх үүрэг” гэж нэрлэгддэг. Бид өсвөр үеийнхээ залуу хүмүүсийг агуу сүнслэг хүч чадлыг бий болгох чадвараа олж харахыг нь хүсдэг. Эдгээр залуу үеийнхний төлөө санаа тавьдаг хүмүүсээс, Их Эзэн биднээс хүсэн шаардах тэр зүйлийг тэдэнд туслахын тулд хийгээч гэж бид гуйж байна. Сүмийн ирээ-

дүй тэднээс хамаарах учир бид бүгдээрээ санаа зовдог.

Дээрх хоёр хөтөлбөрийг сайжруулсан юм. Харин тэдгээрийн зорилго нь хэвээрээ юм. Ерөнхийлөгч Монсон: бид “сурах ёстойгоо сурч, хийх ёстойгоо хийж, ямар хүн болох ёстой, тийм л хүн болох ёстой”² хэмээн хэлсэн билээ.

Залуу эмэгтэйчүүдийн *Хувийн Хөгжил Дэвшил* товхимол нь уг зорилгыг тэдэнд тодорхой хэлж өгдөг: “Хувийн Хөгжил Дэвшлийн хөтөлбөр нь таныг өөрийнхөө хэн болох, та яагаад энэ, дэлхий дээр байгаа болон Бурханы охины хувьд ариун сүмд явж, ариун гэрээнүүдийг байгуулахад бэлтгэхийн тулд юу хийх ёстойг бүрэн дүүрэн ойлгоход туслах Залуу Эмэгтэйчүүдийн эрхэмлэх найман чанарыг ашигладаг.”

Мөн энэ нь, залуу эмэгтэйчүүд “амлалтуудыг өгч, тэдгээрийг биелүүлэх болон хөгжил дэвшилээ эцэг эх, эсвэл удирдагчдаа илтгэх” болно гэж заадаг. Түүнчлэн “Хувийн Хөгжил дэвшил дээрээ – залбирал, судраас суралцах, үйлчлэх болон өдрийн тэмдэглэл дээрээ ажилласнаар энэ нь өдөр тутмын хэвшил болно. Эдгээр хэвшил нь та нарын гэрчлэлийг нэмэгдүүлж мөн амьдралынхаа туршид сурч, хөгжиж дэвшихэд тань туслах болно”³ гэж амладаг.

Аароны санваартай залуу эрэгтэйчүүдэд зориулсан Бурханы өмнө хүлээх үүрэг хариуцлага хөтөлбөр илүү нөлөөтэй, илүү энгийн болсон. Аароны санваарын бүх гурван албан тушаалыг нэг энгийн номонд

багтаасан болно. Залуу эрэгтэйчүүд болон тэдний удирдагчид энэ шинэ номын хуулбарыг авна. Энэ ном чухал туслах хэрэгсэл болно. Энэ нь залуу хөвгүүдийн гэрчлэлийг болон Бурхантай харилцах харилцааг нь бэхжүүлэх болно. Энэ нь тэдэнд санваарын үүргээ мэдэж, биелүүлэхэд нь туслахын хамт эцэг эхтэйгээ харилцах харилцаа, чуулгын гишүүд болон тэдний удирдагчдын хоорондын харилцааг бэхжүүлэх болно.

Энэ хоёр хөтөлбөр хоёул залуу үеийнхэнд, хүч чармайлт гаргах агуу үүрэг хариуцлагыг ноогдуулдаг. Хэнд ч сорилт мэт санагдах тийм зүйлсийг хийж сурахад тэд уригдах болно. Би залуу эрэгтэй байсан үеэ эргэн санахад, надаас нэг ихийг шаардаж байсныг санахгүй байна. Цөөхөн удаа бэрхшээлийг давах туулахаар уригдаж байсан, гэхдээ тун цөөхөн удаа даа. Дээрх хөтөлбөрүүд шаргуу тэвчээр, хүч чармайлт, олон жилийн турш сүнслэг мэдрэмж хуримтлуулж, үргэлж суралцахыг шаарддаг.

Энэ талаар бодож үзээд, энэ авлагуудын агуулга нь, залуучуудад мөн тэднийг хайрладаг бид бүгдэд байх ёстой. Их Эзэнд итгэх итгэлийн бодит үзүүлэлт болохыг би ойлгосон. Тэрхүү итгэл зөвт хүмүүст төлөвшиж байгааг би харсан билээ.

Би тойргуудаар очихдоо Аароны санваартны чуулгуудын үйл ажиллагаатай танилцдаг байсан. Залуу эрэгтэйчүүд суралцах загварыг дагаж, Бурхан өөрсдөөс нь хийхийг хүсдэг зүйлийг хийхээр төлөвлөгөө гаргаж, хийхээр шийдсэн зүйлээ

хийж, сүнслэг байдлын хувьд хэрхэн өөрчлөгдсөнөө бусадтай хуваалцаж байхыг харсан. Залуучууд хэрхэн бат бөх итгэлтэй болон төлөвшсөнөө гэрчлэхийг эцэг, эхчүүд, удирдагчид, найз нар нь, мөн цугларалтан дахь хөршүүд нь сонсоод бат бөх итгэлтэй болсныг, Сүнсийг мэдэрч байгааг би харж, сонссон. Залуучууд гэрчлэлээ хуваалцсанаар тэдэнд туслахыг хичээдэг хүмүүсийн итгэл бас бэхэждэг.

Залуу эмэгтэйчүүдэд сүнслийн хүч чадлыг хөгжүүлж, тэдэнд туслах боломжийг бидэнд олгодог мөн адил загвар Залуу Эмэгтэйчүүдийн хөтөлбөрт байдаг. Хувийн Хөгжил Дэвшил нь залуу эмэгтэйчүүдийг ариун сүмийн ёслолуудыг хүлээн авахад бэлтгэдэг. Тэдэнд ээж нарын, эмээ нарын болон Сүм дэх тэдний эргэн тойрон дахь зөв шударга эмэгтэй хүн болгоны үлгэр жишээ тусалж чадна. Охиныхоо хийж байгаа бүх сайн болгоныг харж, үүнд нь талархсанаар зорилго мөрөөдөлдөө хүрэхэд эцэг эх нь хэрхэн тусалсныг би харсан.

Хэдхэн хоногийн өмнө би нэг ээж залуу охинтойгоо хамт зогсоод гарамгай эмэгтэйчүүдийн үлгэр жишээ болсноор Залуу Эмэгтэйчүүдийн Батламж шагналыг хамтдаа авахыг нь би харлаа. Энэ нь тэдэнд ямар чухал болох талаар тэднийг надтай хуваалцах үед Их Эзэн бид бүгдийг хэрхэн урамшуулан дэмждэгийг би мэдэрсэн билээ.

Эдгээр залуу хүмүүстээ өгч чадах бидний бүхий л тусламжаас хамгийн агуу нь, тэд Бурхан уруу гэртээ

буцаж очих зам дээр байгаа бөгөөд тэд тэнд очиж чадна гэдэгт нь итгэлтэй байдгаа харуулж мэдрүүлэх явдал юм. Мөн тэдэнтэй мөр зэрэгцэн алхсанаараа бид үүнийг хамгийн сайнаар хийж чадна. Уг зам нь заримдаа огцом эгц, чулуурхаг учраас тэд заримдаа шантарч, бүр бүдэрч болзошгүй юм. Тэд заримдаа зорьсон газрынхаа талаар бүдлж, мөн мөнх байдлын хувьд чухал бус зорилгуудыг дагаж төөрч магадгүй юм. Эдгээр сүнслэг хөтөлбөрүүд нь залуу хүмүүсийг Ариун Сүнслийн нөхөрлөлийг урьж, хүлээн авахад хүргэдэг учраас, уг хөтөлбөрийг дагавал төөрөх нь бага байх болно.

Бидний залуу хүмүүст өгөх хамгийн сайн зөвлөгөө нь, тэд гагцхүү Бурханы Сүнсээр удирдагдан чиглүүлэгдсэнээр Тэнгэрлэг Эцэгтээ буцаж очиж чадна гэдгийг хэлэх юм. Тиймээс, бид ухаалаг байвал, Сүнслийн нөхөрлөлийг урих тэр болгоныг урамшуулан, магтаж, үлгэр жишээ болгож үзүүлэх болно. Залуу хүмүүс юу хийж, юуг мэдэрч байгаагаа бидэнтэй хуваалцах үед нь бид ч бас Ариун Сүнслийн хамтрагчид байхаар өөрсдийгөө зохистой байлгах ёстой. Тэд бидний магтаал, инээмсэглэлээс Бурханы сайшаалыг мэдрэх болно. Мөн хэрвээ бид залруулан зөвлөгөө өгөх хэрэгтэй гэж үзвэл, тэд бидний зөвлөгөөнөөс, тэднийг уруу татах Сатаны нөлөөнд авталгүйгээр буруутгал, дорд үзэгдсэн басамжлалыг биш, харин Бурханы хайрыг, бас бидний хайрыг мэдрэх болно.

Бидний үзүүлэх хамгийн чухал үлгэр жишээ бол тэдний хийх ёстой зүйлсийг өөрсдөө хийх явдал юм. Бид Сүнсний бэлгийн төлөө залбирч, судруудыг болон амьд бошиглогчдын үгсийг тунгаан бодох хэрэгтэй. Мөн бид зөвхөн хүсэл мөрөөдлөөр жигүүрлэх төдийгүй гэрээнүүд хийж, төлөвлөгөө гаргах хэрэгтэй. Тэгээд Бурханд өгсөн амлалтаа биелүүлэх хэрэгтэй. Мөн бидний амьдралд ирсэн Цагаатгалын адислалын талаар бид бусадтай хуваалцаж, бусдыг өргөх хэрэгтэй.

Мөн Их Эзэн тэднээс хүсэн хүлээдэг тэрхүү тууштай бөгөөд байнгын итгэлтэй байдлыг бид амьдралдаа харуулж, үлгэр жишээг

үзүүлэх хэрэгтэй. Мөн бид ийнхүү үйлдсэнээр, манай залуучууд тууштай, итгэлтэй хэвээр байвал “. . . Сайн байна, итгэмжит сайн зарц минь! Чи цөөн юманд итгэмжтэй байсан тул чамд ихийг хариуцуулъя. Эзэнийхээ баяр баясгаланд ор”⁴ хэмээн хэлэх Тэнгэрлэг Эцэг болон хайрт Аврагчийнхаа үгсийг сонсох болно гэсэн баталгааг Сүнснээс мэдрэхэд нь бид тэдэнд туслах болно. Мөн тэдэнд тусалсан бид тэдний үгсийг зам дагуу баяр баясалтайгаар сонсох болно.

Их Эзэн та нарт мөн Бурханы хүүхэд бүрд хайртайг би гэрчилж байна. Энэ Сүм бол Бошиглогч Иосеф Смитээр дамжин ирсэн санваарын түлхүүрүүдээр сэр-

гээгдсэн Түүний хаант улс юм. Томас С.Монсон бол өнөөдөр Их Эзэний бошиглогч юм. Та нар Есүс Христийн энэ үнэн Сүм дэх сүнсээр нөлөөлөгдсөн удирдамжийг дагавал, бидний хайрладаг, Тэдэнд тусалдаг манай залуучууд, Тэнгэрлэг Эцэг болон Аврагчтай хамт, үүрдийн баяр баясалд гэр бүлтэйгээ амьдрахаар тэнгэрлэг гэр орондоо аюулгүй эсэн мэнд эргэж очих болно гэдгийг би та бүхэнд амлаж байна. Есүс Христийн нэрээр, амен.

ЭШЛЭЛ

1. 3 Нифай 14:13–14.
2. Томас С. Монсон, “To Learn, to Do, to Be,” *Лиакхона*, 2008 оны 11-р сар, 67.
3. Залуу Эмэгтэйчүүдийн Хувийн Хөгжил Дэвшил (говхимол, 2009), 6.
4. Матай 25:21.